

Засгийн газрын хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР (нэгжийн нэр)-н ХҮНС, ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭР, ХОРШООНЫ АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛТЭН (албан тушаалын нэр) Цэрэн-Адъяа овогтой Пүрэвдулам (албан хаагчийн овог нэр)-н
2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН (ЗАГВАР)

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэл тийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 1. “Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар хүн амын хэрэгцээ хангамжийг сайжруулж, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг дээшлүүлэх зорилтын хүрээнд”							
1	Арга хэмжээ 1.1. “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг үргэлжлүүлэн өрнүүлж, гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэл, хангамжийг нэмэгдүүлэх Хамтран ажиллах гэрээ 8.3.1 заалт, ЗДҮАХ 2.3.1.4	Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний дотоодын үйлдвэрлэлийн хэмжээ, мян. тонн, хүн амын хэрэгцээ хангамжийн хувь	Оны урьдчилсан гүйцэтгэлээр адуу 5668 кг, үхэр-2624 кг, хонь-25034 кг нийт 33326 кг мах зах зээлд борлуулсан.	Төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөнийг орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг иргэдийн төлөөлөгчдийн хурлын 04 дүгээр сарын 19- ний өдрийн 10 дүгээр тогтоолын хавсралтаар 5 жилээр батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хүнсний салбарын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх 2 иргэнд 15,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлсэн. Сумын хүн амын хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний тэнцлийг 1-р улирлаар	2025.01.01- 2025.12.31	70 ✓

					тооцож, Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлсэн.		
2	Арга хэмжээ 1.2. Хүнсний үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх Хамтран ажиллах гэрээ 8.3.2. заалт	Дэмжлэгт хамрагдсан үйлдвэр, аж ахуйн нэгжийн тоо, дэмжлэгийн хэмжээ	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас бүлийн төсөлд хүлэмжид нарийн ногоо тариалах чиглэлээр 3,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна.	Хүнсний үйлдвэр үйлчилгээний чиглэлээр сумын тэргүүлэх чиглэлд оруулж хурлаар батлуулах	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас цагаан идээ боловсруулах 1 иргэнд 5,0 сая төгрөг, махны чиглэлийн үхэр үржүүлэх 1 иргэнд 10,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна.	2025.01.01-2025.12.31	100 70.
3	Арга хэмжээ 1.3. Сум орон нутагтаа үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, шалгарсан бүтээгдэхүүнийг улс, аймгийн үзэсгэлэн худалдаанд оролцуулахад дэмжлэг үзүүлсэн байна. Хамтран ажиллах гэрээ 8.3.5 заалт, Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах, "Аймгийн 5 жилийн төлөвлөгөөний 4.2.1. заалт,	Улс, аймгийн үзэсгэлэн худалдаанд оролцуулсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо Борлуулалтын хэмжээ сая төгрөг	Баян-Өндөр 2024 үзэсгэлэн худалдааг зохион байгуулсан. Өв-Түншлэл-2024 үзэсгэлэн худалдаанд 4 иргэн, Улаанбаатар хотод болсон үзэсгэлэн худалдаанд 1 иргэн оролцсон.	Сум орон нутагтаа үзэсгэлэн худалдаа зохион байгуулах бэлтгэл бэлэн байдлыг ханган, жижиг дунд үйлдвэр эрхлэгчдэд мэдээлэл хүргэн ажилласан байна.	Улаанбаатар хотод зохион байгуулагдсан цагаан сар үзэсгэлэн худалдаанд 2 малчин айраг, цагаан идээ махаар оролцож бүтээгдэхүүнээ борлуулсан. <i>төгрөг хой аж!</i>	2024.01.01-2024.06.01	70 30
4	Арга хэмжээ 1.4. Цэцэрлэг, сургуулийн хоол үйлдвэрлэлд орон нутгаас нийлүүлэх хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний нэр	Орон нутгаас нийлүүлсэн түүхий эд, бүтээгдэхүүний нэр төрөл, тоо хэмжээ тонн	2024 онд төсөвт байгууллагууд сүү, цагаан идээг 4029 кг, 17618,8 сая, төмс, хүнсний ногоо	Худалдан авах үйл ажиллагаанд давуу эрх тооцож засаг	Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа ЕБС, СӨББ-аас хүнсний түүхий эд бүтээгдэхүүний нийлүүлэлтийн судалгааг авч нэгтгэсэн. Судалгааны	2025.01.01-2025.12.31	70 30

	төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлэх Хамтран ажиллах гэрээ 8.3.7		7177,2 кг 17613,4 сая, мах 16096,5 кг 121001,5 сая төгрөгөөр тус тус худалдан авалт хийсэн байна.	даргын гэрээнд тусгаж оруулах	дүнгээр сумын хэмжээнд 2025 оны хагас жилд хүүхдийн хоол үйлдвэрлэлд мах 8,716 тн, төмс 1,72 тн, хүнсний ногоо 1,9 тн, сүү 2,037 тн, сүүн бүтээгдэхүүн 0,64 тн, түүхий эд, бүтээгдэхүүн хэрэглэж байна. Цэцэрлэг, эмнэлэг сургуулийн хоол үйлдвэрлэлд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр байцаагч нартай хамтран зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, албан шаардлага хүргүүлж биелэлтийг тооцон ажилласан.		
5	Арга хэмжээ 1.5. Хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хүнсний зориулалтын бус савны хэрэглээг бууруулах Хамтран ажиллах гэрээ 8.3.8 ЗДҮАХ 2.3.1.5	-Зохион байгуулсан арга хэмжээний тоо -Арга хэмжээнд оролцогчдын тоо -Хүнсний зориулалтын бус савны хэрэглээнээс татгалзсан айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын тоо	Хүнсний аюулгүй байдал 3 сарын аяны хүрээнд төлөвлөгөө гарган хэрэгжилтийг ханган ажилласан. Хүнсний зориулалтын биш хуванцар савны хэрэглээ, хоруу чанарын мэдлэг үнэлэх нэгдсэн судалгааг Google Forms ашиглан 63 иргэнээс авсан. Нийт	Хүнсний зориулалтын бус савны хор хөнөөлийг таниулах, хэрэглээг бууруулах, чиглэлээр хэрэглэгчдийг соён гэгээрүүлэх, төрөл бүрийн сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулах	Хуванцар савны олон улсын ангиллын тэмдэглэгээг хэрэглээнд хэвшүүлэх зорилгоор цахим орчинд мэдээллийн хэрэгслээр нийтэд сурталчлан таниулах арга хэмжээ авч ажилласан. Хүнсний зориулалтын савны үндсэн тэмдэглэгээний талаар гарын авлага хийж малчдад тарааж байна.	2025.01.01-2025.12.31	30 40%

			оролцогчдын 38,7 хувь нь хуванцар савны тэмдэг, тэмдэглэгээний талаар зөв мэдлэгтэй, 61,3 хувь нь буруу мэдлэгтэй байна.				
6	Арга хэмжээ 1.6. Тохирлын үнэлгээ, баталгаажуулалтад хамрагдах хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, бүтээгдэхүүний тоо, хувь хэмжээг нэмэгдүүлэх, хамтарсан хяналт үнэлгээний ажлыг зохион байгуулах, стандартын хэрэгжилтийг сайжруулах Хүнсний хангамж, аюулгүй байдлыг сайжруулах, “Аймгийн 5 жилийн төлөвлөгөөний 5.2.3. заалт	Стандартыг хангаж ажилласан байна.	7 дэлгүүр тохирлын гэрчилгээ авсан.	Тохирлын гэрчилгээний хугацааг сунгуулах дэлгүүрийн материалыг холбогдох стандартын дагуу авч Стандарт хэмжил зүйн газарт дамжуулан сунгуулах	Тохирлын үнэлгээ, баталгаажуулалтад хамрагдах 2 хүнсний дэлгүүрт хамтарсан хяналт үнэлгээний ажлыг зохион байгуулж стандартыг хангуулан холбогдох материалыг бүрдүүлэн ажиллаж байна. Мөн жин хэмжүүрийг баталгаажуулах ажил хийгдсэн байна.	2025.01.01-2025.12.31	70
7	Арга хэмжээ 1.7. Сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчид сумын хэмжээнд хүнсний аюулгүй байдалд хяналт шалгалт хийхэд мэргэжил арга зүйн	Хяналт шалгалтын тоо, зөрчил арилалтын хувиар	Хяналт шалгалтад 8 дэлгүүр хамрагдаж хугацаа дууссан бараа зарж борлуулж байгаа	Хяналт шалгалт зохион байгуулж хамтран ажилласан байна.	Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газрын байцаагч нартай хамтран цагаан сарын урьдчилсан шалгалт болон төлөвлөгөөт шалгалтуудыг худалдааны газрууд, төсөвт байгууллагуудын гал тогоо,	2025.01.01-2025.12.31	70

	зөвлөгөө өгч хамтран ажиллах Хамтран ажиллах гэрээ 8.3.10 Албан тушаалын тодорхойлолт 2 дугаар зорилт 2 дахь заалт		4 дэлгүүрийн 14 төрлийн 223,000 төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг дотоод журмын дагуу устгуулж, 1 дэлгүүрийн хугацаа дууссан 38500 төгрөгийн бараа бүтээгдэхүүнийг буцаалт хийхээр шийдвэрлэсэн.		цайны газруудад газар дээр нь очиж хяналт шалгалт зохион байгуулж, албан шаардлага хүргүүлж биелэлтийг тооцон ажилласан. Шалгалтаар 4 дэлгүүрийн 6 нэр төрлийн 507500 төгрөгийн хугацаа дууссан бүтээгдэхүүнийг дотоод журмын дагуу устгуулж баримтыг хүлээн авсан. Зөвшөөрөлгүй тамхи зарж байсан 2 дэлгүүрийн 107 ширхэг 558000 төгрөгийн тамхийг хураан авч материалыг бүрдүүлж албан тоотын хамт холбогдох газарт дамжуулсан. Мөн сургууль, эмнэлэг, дотуур байр, Аргуйт ширээт, Шивээт цайны газруудад бүртгэлийн дэвтрүүдийг захиалж хүргүүлэн ажилласан.		
8	Арга хэмжээ 1.8. Хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн мэдээг 7 хоног бүрийн 1 дахь өдөр авч ХХААГазарт дамжуулж, программд шивэх ЗДҮАХ- 2.3.1 заалт	График хугацаанд дамжуулсан байна.	Долоо хоног бүрийн 1 дахь өдөр мэдээ авч холбогдох газарт дамжуулсан.	Хагас жилийн байдлаар 7 хоног бүрийн 1 дахь өдөр мэдээ авч дамжуулж, программд шивсэн байна.	Сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа хүнсний 8 дэлгүүрээс хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний нөөцийн мэдээг 7 хоног бүр авч нэгтгэн, хүн амын хүнсний хангамжийн хоногийн нөөцийн тооцоог хийж, мэдээллийг ХХААГазарт хүргүүлэн ажиллаж байна. Нөөцийн мэдээгээр сумын хэмжээнд хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний	2025.01.01- 2025.12.31	100 70

					хүрэлцээ хангамж, нөөц хангалттай байгаа бөгөөд нөөцийн баталгаат байдалд тогтмол хяналт тавин ажиллаж байна. Төлөвлөгөөт болон урьдчилсан шалгалтаар худалдаа, хоол үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуй нэгж, иргэдэд зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж ажилласан.		
9	Арга хэмжээ 1.9. Согтууруулах ундаа худалдах тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан дэлгүүрүүдийн хугацааг сунгуулах, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж, хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах Албан тушаалын тодорхойлолт 2 дугаар зорилт 1 дахь заалт	Хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж тусгай зөвшөөрлийг сунгуулсан байна.	Тусгай зөвшөөрөлтэй 8 дэлгүүр байна.	Хуулийн хэрэгжилтийг хангуулан ажлын хэсэг хуралдаж холбогдох материалыг Хууль зүйн хэлтэст хүргүүлэн сунгалт хийсэн байна.	Тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан 1 дэлгүүрийн хүсэлтийг ХХААГазарт хүргүүлж, хөдөө аж ахуйн байцаагч нартай хамтран худалдаа нийтийн хоолны газруудад цагаан сарын урьдчилсан хяналт шалгалтыг зохион байгуулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн. Архи, согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжийн талаар судалгааг шинэчлэн нэгтгэж, Хүнс, хөдөө аж ахуй газарт дамжуулан ажилласан.	2025.01.01- 2025.12.31	70
10	Арга хэмжээ 1.10. Сумын төвийн ус худгуудад цэвэршүүлэгч төхөөрөмж байршуулна ЗДҮАХ 2.3.1.10 заалт	Цэвэршүүлэх төхөөрөмж тавьсан худгийн тоо	Сумын төвд 2 худга байна.	Орон нутгийн хөгжлийн сангаас 15,0 сая төгрөгөөр 4 сард худалдан авах ажиллагааг	Сумын төвийн худгуудад цэвэршүүлэх төхөөрөмжийг байршуулахаар Засаг Даргын захирамжаар ажлын хэсэг байгуулагдсан. Байгаль орчны газраас усны	2025.01.01- 2025.12.31	70

				зарлаж, төхөөрөмж худалдан авах	дээжийн хариунд үндэслэн цэвэршүүлэх төхөөрөмж худалдан авахаар судалгаа хийгдэж байна.		
Зорилт 2. “Жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд дэмжлэг үзүүлэх замаар сумын бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн хэмжээ болон ажлын байрны тоог нэмэгдүүлэх”							
11	Арга хэмжээ 2.1. “Цагаан алт” үндэсний хөдөлгөөнийг өрнүүлж, орон нутагт сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулах Хамтран ажиллах гэрээ 8.4.1 заалт, ЗДҮАХ 2.3.1.1 заалт	-Зохион байгуулсан арга хэмжээний тоо -Олон нийтэд хүргэсэн мэдээллийн сувгийн тоо -Хамрагдсан иргэдийн тоо	Монгол Улсын Их Хурлын 2024 онд малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэрлэлийг дэмжих зарим арга хэмжээний тухай 63 дугаар тогтоол батлагдсан.	Цагаан алт” үндэсний хөдөлгөөнийг орон нутагт сурталчлан таниулах 1 арга хэмжээг мэдээллийн сувгаар таваас доошгүй удаа сурталчилсан байна.	Цагаан алт үндэсний хөдөлгөөний төр хувийн хэвшлийн зөвлөлдөх уулзалтад цахимаар оролцсон. Цагаан алт хөтөлбөрийн хүрээнд малчдадаа хоршоодоор дамжуулан Ноос-Ирээдүй ХХКомпанид ноосоо тушааж хамтран ажиллах Аймгийн Засаг даргын уриалгыг хоршоодод болон цахим орчинд мэдээллийн хэрэгслээр нийтэд сурталчлан таниулах арга хэмжээ авч ажилласан.	2025.01.01- 2025.12.31	70
12	Арга хэмжээ 2.2. Мал аж ахуйн гаралтай түүхий эд бэлтгэх, анхан шатны боловсруулалт хийх иргэн, аж ахуйн нэгжийг дэмжих Хамтран ажиллах гэрээ 8.4.2 ЗДҮАХ 2.3.1.3	-Дэмжсэн аж ахуйн нэгжийн тоо -Дэмжлэгийн хэмжээ	Сумын хэмжээнд 2024 онд 2 хоршоо сургалт арга хэмжээнд хамрагдсан байна.	Сумын тэргүүлэх чиглэлд оруулж Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулах	ЖДҮГазраас 5 жилийн хугацаатай хүүгүй лизингээр 20 хувийн урьдчилгаатай олгох арьс, нэхий элдэж боловсруулах тоног төхөөрөмжийн мэдээллийг цахим орчинд сурталчлан ажилласан. Малын гаралтай түүхий эдийн агуулахын судалгааг гаргаж, албан тоотын хамт холбогдох газарт дамжуулсан.	2025.01.01- 2025.12.30	40 30
13	Арга хэмжээ 2.3. “Шинэ хоршоо” хөдөлгөөнийг	-Дэмжлэгт хамрагдсан хоршоодын тоо	Сумын хэмжээнд 21 хоршоо	Шинээр малчны хоршоо байгуулагдан,	Шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд нийт 22 хоршооны 73 малчин 2 тэр бум 687,6		70

	эрчимжүүлж, санал санаачилгатай малчдыг бүх талаар дэмжих, холбогдох ТББ, мэргэжлийн холбоодтой хамтран хоршоодыг чадавхжуулах сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах Хамтран ажиллах гэрээ 8.4.3 ЗДҮАХ 2.2.3, Албан тушаалын тодорхойлолт 3 дугаар зорилт 2 дахь заалт	-Хөнгөлөлттэй зээлийн хэмжээ -Зохион байгуулсан сургалт арга хэмжээ -Хамрагдсан хоршоодын тоо	байгуулагдаж 2 тэрбум 167 сая төгрөгийн урамшуулалд хамрагдсан.	хөнгөлөлттэй зээлийн болон мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж, чадавхжуулсан байна.	сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан байна. Үүнээс 558,8 сая төгрөгийг батлан даалтын санд хамрагдсан. Хаан банкнаас 7 хоршооны 12 малчин 475,0 сая төгрөг, Төрийн банкнаас 15 хоршооны 61 малчин 2 тэрбум 2,212,6 сая төгрөгийн санхүүжилт авсан байна. Үүнээс 2025 онд 4 хоршооны 10 малчин 261,6 сая төгрөгийн санхүүжилт авсан. 2025 онд шинээр 3 хоршоо байгуулагдсан байна. Сумын тусгай хэрэгцээний газар болох Бөмбий багийн атаршсан талбайд тариалан эрхлэх хүсэлтэй 7 хоршоонд 210 га талбайг тариалангийн зориулалтаар ашиглуулахаар түрээсийн гэрээ байгуулсан. Баян арвай бөмбий хоршооны 2 гишүүн Өвөрхангай аймгийн газар тариалангийн бүс болох Хархорин суманд тариаланчдын зөвлөгөөнд оролцож, үр тариа малын тэжээлийн чиглэлээр туршлага судалсан.	2025.01.01-2025.12.31	
14	Арга хэмжээ 2.4. Аймгийн тэргүүлэх чиглэлтэй уялдуулан хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох салбар,	Журмын дагуу тэргүүлэх чиглэлийг хурлаар батлуулж санд ирсэн төслүүдийг шийдвэрлэсэн байна.	Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар 2024 оны тэргүүлэх чиглэлийг	Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар оруулж батлуулсан байна.	Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 03/05 дугаар тогтоолоор хоршоо хөгжүүлэх сангийн тэргүүлэх чиглэл, хурлын тов, төсөл	2025.01.01-2025.12.31	100 20

	чиглэлийг тогтоож батлуулах Албан тушаалын тодорхойлолт 4 дүгээр зорилт 1 дахь заалт:		батлуулан ажилласан.		сонгон шалгаруулах хороо, хяналтын зөвлөлийг шинэчлэн батлуулсан.		
15	Арга хэмжээ 2.5. “Хоршоо хөгжүүлэх санг”ийн эргэн төлөлтийг сайжруулах, чанаргүй зээлийн хэмжээг бууруулах, төсөл зарлах, хүлээн авах, мэдээллийн санд оруулж, мэдээлэх, хяналт тавих тайлагнах. Албан тушаалын тодорхойлолт 4 дүгээр зорилт 2 дахь заалт:	Төсөл шалгаруулалт хууль тогтоомжийн хүрээнд ил тод нээлттэй явагдаж үр дүнд хүрсэн байна.	Хоршоо хөгжүүлэх сангийн хурлын товыг 2 удаа зарласан.	Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хоршоо хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах хорооны хурлын тов тогтоолгож санхүүжилтийг олгосон байна.	Хоршоо хөгжүүлэх сангийн зээлийн гэрээний хугацаа дуусаагүй идэвхтэй байгаа 13 зээлдэгч байна. Үүнээс зээлийн гэрээний хугацаа дууссан, явцын хугацаа хэтрэлттэй зээлдэгч байхгүй. Идэвхтэй байгаа зээлдэгч нарыг хоршоо хөгжүүлэх сангийн программд оруулж, сар бүрийн төлөлтийг шивж төв рүү дамжуулан ажиллаж байна. Хоршоо хөгжүүлэх сангийн төсөл хүлээн авах зарыг албан ёсны сайт, группээр нийтлэн зарлаж 1 хоршооны материалыг хүлээн авч, төсөл сонгон шалгаруулах хороо хуралдаж 70,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож мэдээллийн санд оруулсан.	2025.01.01- 2025.12.31	100

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэн түвшин	Хүрсэн (биелэлт) түвшин	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
16	Арга хэмжээ 3.1. Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах,	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн	Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулан	Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн	Гүйцэтгэлийн төлөвлөгөөг гаргаж баталгаажуулан хагас	2025.01.01- 2025.12.30	70

	төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх Албан тушаалын тодорхойлолт 5 дугаар зорилт 8 дахь заалт:	төлөвлөгөө, тогтоол шийдвэрийн биелэлт, хугацаатай тайлан мэдээг тогтмол гарган тайлагнах	батлуулж, төлөвлөгөөний биелэлтийг гарган ажилласан.	төлөвлөгөө, тогтоол шийдвэрийн жилийн эцсийн тайлан, хугацаатай тайлан мэдээг тогтмол гарган холбогдох байгууллагад хүргүүлсэн байна.	жилээр биелэлтийг тайлагнасан. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын аймгийн засаг даргатай 2025 онд хамтран ажилласан гэрээний үүргийн хэрэгжилт, шинэ хоршоо хөдөлгөөний салбар дундын уялдааг хангах үндэсний хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтийг тогтоосон хугацаанд нь гаргаж холбогдох албан тушаалтанд хүргүүлсэн. Сар бүр хийсэн ажлын жагсаалтаа гаргаж холбогдох мэргэжилтэнд дамжуулсан.		
17	Арга хэмжээ 3.2. Архив, албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомжийг албан бичиг боловсруулах үйл ажиллагаандаа мөрдлөг болгон хэрэгжүүлж ажиллах Албан тушаалын тодорхойлолт 5 дугаар зорилт 6 дахь заалт:	Албан хэрэг хөтлөлтийн стандартыг хэрэгжүүлж, мэдлэг чадвараа дээшлүүлсэн байна.	Урд оны материалыг архивлан холбогдох албан хаагчид хүлээлгэн өгсөн.	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу урд оны материалыг архивлан холбогдох албан хаагчид хүлээлгэн өгөх	Архив албан хэрэг хөтлөлтийн талаарх хууль тогтоомжийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.	2025.01.01-2025.12.31	100
18	Арга хэмжээ 3.3 Монгол Улсын засгийн газар болон өөрийн хариуцсан	Холбогдох шийдвэр, хэрэгжилт,	"Хүнсний хангамж, аюулгүй	Хууль тогтоомж шийдвэрийг хяналтдаа бүрэн	"Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөн,		70

					комисс, Дүк машин хүлээн авах ажлын хэсэгт тус тус орж ажилласан.		
--	--	--	--	--	--	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
			Суурь түвшин				
	1	2	3	4	5	6	7
1	Арга хэмжээ 1. Хур системийн операторын үүрэг гүйцэтгэх	Мэдээлэл лавлагаа авсан иргэдийн тоогоор	Хур системээс 420 лавлагаа гаргасан байна.	Мэдээлэл лавлагаа авсан тоо урьд оноос өссөн байна.	Хур системийн операторын үүрэг гүйцэтгэж орон нутагт төрийн цахим үйлчилгээ үзүүлэх операторын сургалтад цахимаар хамрагдсан. 2025 онд 230 лавлагаа гаргаж иргэдэд үйлчилсэн байна. Үүнээс лавлагаа 218, олон шатлалт үйлчилгээ 11, нэг шатлалт 219 байна.	2025.01.01-2025.06.01	100
2	Арга хэмжээ 2. Ёс зүйн дэд хороог ажиллуулах	Ёс зүйн дэд хорооны хүлээн авсан өргөдөл гомдлын тоогоор	Ёс зүйн сургалтад хамрагдсан	Ёс зүйн дэд хорооны төлөвлөгөө гарган системд оруулах, албан хаагчдыг сургалтад хамруулах, судалгаа авах	Ёс зүйн дэд хороодын цахим сургалт, Өвөрхангай аймагт бүсчилсэн хөгжил хангайн бүсийн зөвлөгөөнд 2 өдөр хамрагдсан. Ёс зүйн дэд хорооны самбарыг шинээр хийж, мэдээ мэдээллийг байршуулж, 2025 онд хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлуулж веб сайтад байршуулсан. Ёс зүйн	2025.01.01-2025.12.31	70

					тухай хуулиар тамгын газрын албан хаагчдад сургалт зохион байгуулан талархлын захидлын аян өрнүүлж байна.		
--	--	--	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

Хүнс, жижиг дунд үйлдвэр
 хоршооны асуудал хариуцсан
 мэргэжилтэн
 (Албан тушаал)

Ц.Пүрэвдулам /...../
 (Нэр, гарын үсэг)

2025.06.10
 (Огноо)

